

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-
62000084 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙН
ДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



**Улаанбаатар хот
2024 он**

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	1
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	1
НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төсөл хэрэгжүүлэгч болон төслийн талаарх товч танилцуулга	2
1.2 Төслийн талбайн байршил	3
1.3 Төслийн хүчин чадал	5
1.4 Ашиглалтын системийн сонголт	5
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
2.1 Физик газарзүйн нөхцөл	6
2.2 Уур амьсгал.....	6
2.3 Агаарын чанар	7
2.4 Хөрсөн бүрхэвч	7
2.5 Ургамлан нөмрөг	7
2.6 Амьтны аймаг	7
2.7 Геологийн тогтоц болон геоморфологи	7
2.8 Гадаргын болон газрын доорхи ус.....	8
2.9 Тусгай хамгаалттай газар нутаг	8
2.10 Түүх соёлын өв	8
2.11 Нийгэм эдийн засгийн байдал.....	8
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	9
3.1 Агаарын чанар	9
3.2 Физик бохирдол, хог хаягдал	10
3.3 Геологийн тогтоц ба геоморфологи	10
3.4 Гадаргын болон газрын доорх ус.....	10
3.5 Хөрсөн бүрхэвч	11
3.6 Ургамлан нөмрөг	11
3.7 Амьтны аймаг	11
3.8 Нийгэм эдийн засаг	11
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	13
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	30

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талаарх товч танилцуулга	2
Хүснэгт 2. Төслийн талбайн газарзүйн солбилцол.....	3
Хүснэгт 3. Уурхайн календарьчилсан төлөвлөлт	5

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн сансрын зураг.....	4
Зураг 2. Төслийн талбай орчмын төлөв байдал	6
Зураг 3. Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас ялгарах TSP тоосны тархалт, мкг/м ³	9
Зураг 4. Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас ялгарах TSP тоосны тархалт, мкг/м ³	10

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч болон төслийн талаарх товч танилцуулга

Хүснэгт 1. Төслийн талаарх товч танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч	“Арвайндэвшил” ХХК Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 1011003015, Регистрийн дугаар: 5172152 Хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр, 12-р баг, Зүлэгт, үйлдвэрлэл-6, 601 тоот Утас: 99328958
Төслийн нэр	“Өвдөг худаг” нэртэй тоосгоны шаврын орд
Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-62000084 Өвөрхангай аймаг Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өвдөг худаг” нэртэй MV-62000084 тоот дугаартай тусгай зөвшөөрлийг Өвөрхангай аймгийн засаг даргын тушаалаар 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр 1011003015 тоот улсын бүртгэлийн дугаартай “Арвайндэвшил” ХХК-д олгосон байна.
Төслийн зорилго, ач холбогдол	Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын нутагт орших “Өвдөг худаг” нэртэй ордыг байгаль орчинд ээлтэй аргаар олборлож, тоосгоны үйлдвэрийг ажиллууснаар хөдөө орон нутгийн барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, орон нутаг, компани, улсын эдийн засагт үзүүлэх эерэг үр нөлөөг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.
Техник эдийн засгийн үндэслэл тушаал, дүгнэлт	Өвдөгхудаг тоосгоны шаврын ордын MV-62000084 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлын ХХ-13-02 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан УГА-ны даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн Н/26 дугаар тушаалаар В+С зэрэглэлээр 586.9 мян.м³ тоосгоны шаврын нөөц бүртгэжээ. Төсөлд ашиглалтын үеийн хаягдал 12.3% буюу 66,003.6 м³ байхаар тооцож геологийн бодитой В, боломжтой С зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадлан В нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нөөц нийт 469,403.2 м³ тоосгоны шавар байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 194,261 м³ хөрс хуулалт хийхээр тооцож жилд 10.0 мян.м³ тоосгоны шавар олборлож хүчин чадалтайгаар 50 жилийн хугацаанд олборлохоор төлөвлөсөн байна.
Эдийн засгийн тооцоолол	Төсөл нь нийт 2213.72 сая төгрөгийн татвар төлбөр улс орон нутгийн төсөвт оруулах ба үүнээс улсын төсөвт 1809.13 сая төгрөг, Орон нутаг хөгжлийн санд 404.59 сая төгрөгийг оруулна. Эдийн засгийн үр ашгийн тооцоогоор төсөл нь хөрөнгө оруулалтаа 2.47 жилийн дараа нөхөх бөгөөд төслийн дотоод өгөөжийн норм (IRR) нь 40 %, өнөөгийн мөнгөний ирээдүйн үнэ цэнэ нь NPV 10 % байхад 1742.2 сая төгрөг байхаар харагдаж байгаа бөгөөд улс орон нутгийн төсөвт нийт 2213.72 сая төгрөгийн татвар хураамж төлнө.
Ашиглалтын технологи	Ордыг нэг түвшингээр, тэсэлгээгүй, ил уурхайн авто тээвэртэй ашиглалтын системээр улирлын чанартай ашиглах юм. Тухайн газар орны уур амьсгалын байдалд үндэслэн уулын ажлын 05 сарын 01-ээс 07-р сарын 01 хүртэл явуулах боломжтой. Уурхай нь өдрийн 1 ээлжийн зохион

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	байгуулалттай ба долоо хоног бүрийн 6 өдөр ажиллана. Харин тоосго шатаах үйлдвэр нь 05 сарын 01-ээс 10-р сарын 01 хүртэл ажиллана.
--	--


1.2 Төслийн талбайн байршил

“Арвайндэвшил” ХХК-ийн Өвдөг худаг нэртэй MV-62000084 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Улаанбаатар хотоос 460 км, Арвайхээр хотоос зүүн тийш 30 км, Зүүнбаян-Улаан сумаас зүүн урагш 56 км зайд байрлана. MV-62000084 тоот тусгай зөвшөөрөлтэй талбай нь 11 цэгээс бүрдсэн, 31.55 га талбайг эзлэн оршино.

Хүснэгт 2. Төслийн талбайн газарзүйн солбилцол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	103	10	31.5	46	14	22.84
2	103	10	31.58	46	14	22.84
3	103	10	31.58	46	14	28.29
4	103	9	45	46	14	28.29
5	103	9	45	46	14	22.84
6	103	9	45	46	14	14.7
7	103	9	49.71	46	14	14.7
8	103	9	49.71	46	14	20.57
9	103	10	16.17	46	14	20.57
10	103	10	16.17	46	14	14.7
11	103	10	31.5	46	14	14.7

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ”
ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1. Төслийн талбайн сансрын зураг

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1.3 Төслийн хүчин чадал

Уурхайн жилийн хүчин чадлыг “Арвайндэвшил” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу болон тоосго шатаах үйлдвэрийн жилийн хүчин чадлаас хамаарч сонголоо. Өвөрхангай аймгийн төв дээр байрлах тоосго шатаах үйлдвэрийн хувьд жилд 3-5 сая ширхэг тоосго үйлдвэрлэх ба 9600-16000 м³ шавар хэрэглэдэг. Иймд Өвдөг худаг ордын жилийн хүчин чадлыг 10000 м³ –ыг 50-н жилийн хугацаанд ашиглана. Доорх тооцоонд эхний 10 жилийн календарьчилсан төлөвлөлт, олборлох шаврын хэмжээ болон хуулах хөрсний хэмжээг харууллаа.

Хүснэгт 3. Уурхайн календарьчилсан төлөвлөлт

Үзүүлэлт	Х.нэгж	Ашиглалтын жилүүд						Нийт
		1	2	3	4	5	6-10	
Уулын цул	м ³	9761.9	11904.8	11904.8	11904.8	11904.8	59523.8	116904.8
Хөрс хуулалт	м ³	1561.9	1904.8	1904.8	1904.8	1904.8	9523.8	18704.8
Олборлох шаврын хэмжээ	м ³	8200.0	10000.0	10000.0	10000.0	10000.0	50000.0	98200.0
Хөрс хуулалтын коэффициент	м ³	0.19	0.19	0.19	0.19	0.19	0.19	0.19

1.4 Ашиглалтын системийн сонголт

Өвдөг худаг тоосгоны шаврын ордын хүрээнд хучаас хөрс 0.8 метр бөгөөд шаврын давхаргын дундаж зузаан 2.6 м. Ордод малтсан шурфуудад хөрсний ус илрээгүй. Мөн олборлолт явуулах өөрсдийн хөрөнгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бэлэн.

Дээрх нөхцөлүүдийг үндэслэн ордыг хаягдал багатай үр ашигтай олборлохын тулд хучаас хөрсийг экскаватороор ухаж шидэн, утгуурт ачигчаар автосамосвалд ачиж шимт хөрсний овоолгод буулгана. Шаврыг экскаватораар автосамосвалд ачин олборлосон шавраа төслийн талбайгаас баруун тийш 30 км-ын зайд Өвөрхангай аймгийн төвд байрлах тоосго шатаах үйлдвэр рүү тээвэрлэх ашиглалтын системийг сонгов. Шаврыг олборлолтын нэг түвшингээр, тэсэлгээгүй, ил уурхайн авто тээвэртэй ашиглалтын системээр олборлоно.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Физик газарзүйн нөхцөл

Монгол орны газар зүйбайгалийн мужлалаар Хангай нурууны зүүн өмнөд салбарын уулархаг ойт тайгын өврөөс эх авсан Онгийн голын сав, дов толгод бүхий талархаг хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 2000 орчим метрийн өндөрт оршдог.

Тус талбайн уул нурууд нь мөлгөр тэгш оройтой, хоорондоо зэрэгцээ байрлалтай урт нарийн хөндий, хөдлөлөөр тусгаарлагдсан хэд хэдэн уул нуруудаас тогтоно. Эдгээр хөндий хотгорууд нь 1.0-5.0 км өргөнтэй, 3-5 хэмийн налуу бэл үүсгэнэ. Орд нь Умард Монголын атираат системийн Хангай Хэнтийн структуртектоникийн бүсийн өмнөд захад байрладаг. Төслийн талбайгаас зүүн урд зүгт 9-10 км зайд далайн түвшнээс дээш 1653 м-ийн үнэмлэхүй өндөрт Зодох уул, баруун зүгт 7-8 км Өн цагаан уул /1721м/ тус тус байрлаж байна. Төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1570-1684 метрийн үнэмлэхүй өндөрт байрласан байна. Газрын гадаргын хэвгий буюу налуу төслийн талбай орчимд 0-1.98 (градус)-т байна.



Зураг 2. Төслийн талбай орчмын төлөв байдал

2.2 Уур амьсгал

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны төв хэсэгт оршдог Хангайн бүсийн нутаг дэвсгэрт харьяалагдах¹ бөгөөд далайн түвшнээс дээш 1570-2599 м-ийн дундаж өндөрт оршино. Төв Азийн геоморфологийн их мужид хамаарах бөгөөд гандуу дулаан зунтай, хүйтэн өвөлтэй. Уур амьсгалыг бүрдүүлэгч үндсэн хүчин зүйл болох нарны энергийн хувьд нарны нийлмэл цацраг 6 сард 650 МДж/м²-аас бага, 12 сард 150-

¹ Монгол орны физик газарзүй УБ 1969

250 МДж/м², жилийнх 5000-5500 МДж/м² хүрнэ. Байгаль цаг уурын хувьд эрс тэс, эх газрын уур амьсгалтай. Салхины хурд 5-8 м/сек, жилийн нийлбэр хур тунадас дунджаар 256 мм. Хоногийн дундаж агаарын температур 0⁰-аас дээш байх хугацаа дунджаар 200-217 хоног, -40⁰С-ээс хүйтэн байх өдрийн тоо 1-10 хоног. Агаарын үнэмлэхүй их температурын дундаж 15-20⁰С. Агаарын үнэмлэхүй бага температурын дундаж -20⁰С ба түүнээс бага, хамгийн хүйтэн сарын үнэмлэхүй бага утга -35.6⁰С байдаг. Цочир хүйтрэл намар 9-р сарын 16, хамгийн хожуу нь 10-р сарын 8-аас эхэлнэ. Цасан бүрхүүлийн дундаж зузаан 5-10 см бөгөөд 140-160 хоног үргэлжилнэ.

2.3 Агаарын чанар

Хээрийн судалгааны үед төслийн үйл ажиллагаа эхлээгүй байсан учир үйл ажиллагаанаас үүдэлтэй агаарын бохирдуулагч байхгүй төслийн талбай, түүний орчмын агаар дахь том, жижиг ширхэглэгт тоосонцрууд (PM2.5, PM10) Монгол Улсын агаарын чанарын стандарт (MNS 4585:2016)-ын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага байна. Харин төслийн үйл ажиллагаа эхэлснээр шавар уриншлах технологийн үе шат бүрээс тоос гарах бөгөөд хүчтэй салхитай өдөр талбайгаас хийсэх тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс их байх үндэстэй.

2.4 Хөрсөн бүрхэвч

Төслийн талбайн хөрсөн бүрхэвч Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хар хүрэн, хөрсний дэд бүс, Бүрд-Баянцагааны тойрогт хамаарагдана². Жинхэнэ хүрэн хөрс нь далайн түвшнээс дээш 1684-1798 м үнэмлэхүй өндөрт байрласан толгодын бэл тэгш талыг хамарч тогтворжсон байна. Газрын гадаргын налуу буюу хэвгийн 0.0⁰-1.98⁰ (градус) байна.

2.5 Ургамлан нөмрөг

Төслийн талбай болон түүний орчмын газар нутаг нь Монгол орны байгалийн бүс бүслүүрийн мужлалаар хээрийн бүсэд багтана. Хялгана-хазаар өвст-шарилжит ургамалжилт тархана. Ширэг өлөн (*Carex duriuscula*), Шүүрэн шарилж (*Artemisia scoparia*), Хос шүдлэг сонгино (*Allium bidentatum*), Крыловын хялгана (*Stipa krylovii*), Арзгар голгэсэр (*Aster hispidus*), Амманы сэдэргэнэ (*Convolvulus ammannii*), Дэрвээн хазааргана (*Cleistogenes squarrosa*), Нарийн навчит цахилдаг (*Iris tenuifolia*), Гялгар дэрс (*Achnatherum splendens*), Өлчир шарилж (*Artemisia frigida*), Адамсын шарилж (*Artemisia adamsii*), Имт гичгэнэ (*Potentilla bifurca*), Үетнэрхүү гэсэрдэй (*Arctogeron gramineum*), Шовх навчинцарт ортууз (*Oxytropis oxyphylla*) зэрэг ургамлууд ургана. 5-6 сарын дунджаар тусгагийн бүрхэц 13%, 5 ц/га ургацтай.

2.6 Амьтны аймаг

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хойт говь, Говь-Алтай, Монгол Дагуурын тойрогт багтдаг³. Төслийн талбай орчимд хээрийн хөхтөний бүлгэмдлийн огдой, оготно зонхилон оршино. Мөн хээрийн оготно, шар үнэг элбэг, дагуур огодой, урт сүүлт зурам, орог зусаг, дорнодын шишүүхэй, байгалийн шишүүхэй, хэргэлзий зурам цөөн тоотой тохиолдоно. Мэрэгч амьтдаар хооллодог мануул, хээрийн солонго зэрэг махан идэшт хөхтөн амьтад идэш тэжээл даган үе үе тохиолдоно. Төслийн орчимд ховор хөхтөн, ховор шувуу бүртгэгдээгүй.

2.7 Геологийн тогтоц болон геоморфологи

Умард Монголын атираат системийн Хангай Хэнтийн структур-тектоникийн бүсийн өмнөд захад байрладаг. Талбай орчимд доод карбоны Дулаанхайрхан формацын тунамал чулуулаг, доод-дунд юрийн Сайхан-Овоо формац, неогений ангилагдаагүй хурдас болон орчин үеийн хурдасууд тархжээ. Тус ордын ашигт хуримтлал агуулагч неогений (N) хурдас нь доод-дунд юрийн Сайхан-Овоо формацын хурдсыг үл

² Д. Доржготов 2003

³ А.Г. Банников 1954

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

нийцлэгээр хучиж, орчин үеийн сэвсгэр хурдсаар хучигдсан байдаг. Найрлагын хувьд цайвар бор өнгөтэй, төрөл бүрийн найрлагатай хэмхдэсүүд бүхий элс шавранцар, элс хайрганцар, улаан хүрэн өнгийн шаврын үеүүдээс тогтох ба ашигт давхарга болох улаан хүрэн өнгийн шаварлаг хурдасны зузаан нь 0.5-10.0 м хүртэл зузаантай байна.

Тухайн талбай нь Төв Монголын атираат мужийн Хангайн нурууны өмнөд хэсгийн өргөгдлийн бүсэд орших ба 1600-1700 м үнэмлэхүй өндөртэй намхан уулс, гүвээ толгодорхог нутагт хамрагддаг. Төслийн талбай нь уулс, толгод гүвээ, хөндий хосолсон гадаргуутай, энэхүү геоморфологийн элементүүд нь ерөнхийдөө уртрагийн дагуу нарийн зурвас үүсгэн сунаж байрладаг.

2.8 Гадаргын болон газрын доорхи ус

Судалгааны талбай нь гидрогеологийн нөхцөлийн хувьд Монгол орны гадагш урсгалгүй усан хагалбарын сүлжээний томоохон ай сав болох Онгийн голын зүүн салааны нэг хэсэгт оршдог. Онгийн гол нь усан хагалбар сайн хөгжсөн Хангайн нурууны эх авч жижиг гол, горхи, түр зуурын усны урсацаар сэлбэгдэн Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгуудын нутгийг дамжин Улаан нуурт цутгадаг. Орд нь Онгийн голын зүүн хойд хэсэгт тус голын ай савд багтах хөндийн захад орших бөгөөд уг хөндий нь улирлын байдлаас хамаарч хавар, зуны улиралд түр зуурын урсгал устай байх ба жилийн ихэнх хугацаанд урсгал усгүй байдаг.

2.9 Тусгай хамгаалттай газар нутаг

Өвөрхангай аймгийн нутагт Улсын тусгай хамгаалттай Орхоны хөндий, Хангай нуруу, Хөгнө-тарна, Батхаан уул, Хүйсийн найман нуур хэмээх нийт таван газар бүртгэгдэв. Төслийн талбайд хамгийн ойр байрлах Хангайн нуруу БЦГ нь төслийн талбайгаас баруун хойд зүгт 90 км-ийн зайд, баруун хойд зүгт 106 км-ийн зайд Хүйсийн найман нуур БЦГ тус тус байрлаж байна.

2.10 Түүх соёлын өв

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан Өвөрхангай аймгийн Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалын 13 газар байна. Төсөл хэрэгжиж буй Зүүнбаян-Уул суманд Ар цохиотын хадны зураг, Бичигт хадны зураг, бичээс, Онгийн голын буган чулуун хөшөө, Тоонот агуйн зураг, бичээс бүхий Өвөрхангай аймгийн хамгаалтад байх түүх, соёлын дурсгалууд байна.


2.11 Нийгэм эдийн засгийн байдал

“Өвдөг худаг” тоосгоны шаврын ордыг ашиглах төсөл хэрэгжсэнээр улс орон нутгийн төсөвт татвар төлбөр хэлбэрээр нийт 2213.72 сая.төг төвлөрүүлэх бөгөөд 22 хүний ажлын байр бий болж, нутгийн хүн ам ажлын байртай болсноор орон нутгаас бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэх, үйлчилгээний салбарт өсөлт гарах замаар эерэг нөлөө үзүүлэх бөгөөд бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг тодорхой хэмжээгээр дэмжих өндөр ач холбогдолтой юм.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ


3.1 Агаарын чанар

Ил уурхайн олборлолтын үйл ажиллагаа нь агаар орчинд үүсэх тоосжилт, хүнд оврын машин техник, дуу чимээ зэрэг нь агаар орчинд төдийгүй орчны экосистем, орон нутгийн иргэдийн аж амьдралд сөргөөр нөлөөлж байна. Уурхайн ойр орчимд үүсэх тоосжилтыг багасгахын тулд бохирдуулах эх үүсвэрүүдэд хяналт тавих, агаарын чанар болон орчны хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллагаар улирал тутамд хийлгэх, цаг агаарын хэт хуурайшилттай үед тээвэрлэлт, зам талбайгаас үүсэх тоосжилтыг бууруулахын тулд тоос дарагч бодис ашиглах шаардлагатай тохиолдолд услагаа хийх, том оврын тээврийн хэрэгслийн зам талбайг тэмдэгжүүлэх шаардлагатай ба агаар орчин бохирдуулах, дуу чимээний нөлөөллийг хэмжих хяналт шинжилгээ хийх, нөлөөллийг бууруулах зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллах хэрэгтэй.



Зураг 3. Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас ялгарах TSP тоосны тархалт, мкг/м³

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 4. Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас ялгарах TSP тоосны тархалт, мкг/м³

3.2 Физик бохирдол, хог хаягдал

Хог хаягдал хаях цэг, машин техникийн засвар үйлчилгээний цэг, шатах тослох материал хөрсөнд нэвчих, орчны эрүүл ахуйн бүсийг стандартын дагуу хийгээгүйгээс хог хаягдал хийсэх, ойролцоох орчинд эвгүй үнэр тархах зэргээр физик бохирдлууд үүсэх, цаашлаад тухайн орчинд экосистемийн доройтол үүсэж болзошгүй байна.

Иймээс “Арвайндэвшил” ХХК нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг ангилан ялган тусгай цэгт цуглуулж, төвлөрсөн цэгт тушаах, ШТМ-ын хаягдлыг хуримтлуулан хаягдал авах газарт хүргүүлэх, гэрээ хийн хамтран ажиллах хэрэгтэй.

3.3 Геологийн тогтоц ба геоморфологи

Уурхайн үйлдвэрлэлийн нөөц 51.82 мян.м³ элс бөгөөд 1 жилийн хугацаанд олборлоно. Уурхайн олборлолт, бүтээн байгуулалтын нөлөөгөөр нийт 8.23 га талбайн газрын гадарга, хэвлий, геологийн тогтцод өөрлөлтийг бий болгоно.

Уурхайн олборлолтын үед үүсэх карьер, эвдрэлд өртсөн талбайн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал, стандартын дагуу хийж олборлолтод өртсөн талбайг байгалийн унаган төрхөд дөхүүлэн хэлбэржүүлж уурхайн нөхөн сэргээлт хаалтын ажлыг чанарын өндөр түвшинд хийх шаардлагатай.

3.4 Гадаргын болон газрын доорх ус

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон гүний усанд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь усны нөөц багасах, хэрэглээнээс бохирдол үүсэх, шатахуун болон шингэн хаягдлын улмаас гүний ус бохирдох зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

Усны хэрэглээнээс хамаарч холбогдох байгууллагаар /Орон нутгийн захиргаа, аймгийн байгаль орчны газар/ ус ашиглах дүгнэлт гаргуулан, ус ашиглах гэрээ байгуулж хамтран ажиллах, Усны шинжилгээг тогтмол хугацаанд мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораториуд болох Шинжлэх ухааны академи Газарзүй-Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лаборатори, ХанЛаб ХХК усны шинжилгээний лаборатори-уудаас

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

сонгон усны шинжилгээ хийлгэх, Усны тухай хуулийн 24.4-д зааснаар ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах хэрэгтэй.

3.5 Хөрсөн бүрхэвч

Уурхайн карьер, тоосго шатаах үйлдвэрийн барилга байгууламж, уурхайн гадаад дотоод тээвэр, ахуйн хог хаягдал зэргээс хөрсөн бүрхэвчид эвдрэл бохирдол үүснэ. Мөн уурхайн шимт хөрс хуулалт, түүний овоолго үүсгэх хадгалалтыг зохих стандартын дагуу хийгээгүйгээс хөрсний бохирдол доройтол үүсч болзошгүй байна.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд техник хэрэгслийн явах замын маршрут гаргаж тэмдэгжүүлэх, шимт хөрсний овоолгыг зохих стандартын дагуу (Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт **MNS 5916:2008**) хадгалах, ахуйн болон техникийн шатах тослох материалын бохирдлоос сэргийлэхийн тулд ахуйн хог хаягдлыг тогтоосон цэгт байршуулж зөөвөрлөн хаях, техникийн засвар үйлчилгээг уурхайн засвар үйлчилгээний цэгт хийх шаардлагатай.

3.6 Ургамлан нөмрөг

Олборлолтын ажлын үед шинээр үүсэх карьер ашиглалтын орон зайн ургамлан нөмрөг өртөж устаж доройтох, уурхайн тээвэрлэлт хөрс хуулалтын ажилтай холбоотойгоор тоосжилт ихээр үүсэн ургамлан нөмрөгийн өсөлт хөгжилтөд нөлөөлөх, малын бэлчээрийн ургамалжилтад нөлөөлснөөр бэлчээрийн таваарлаг шинж чанар алдагдах зэрэг сөрөг нөлөөллүүд үүсч болзошгүй байна.

Уурхайн олборлолтын талбайгаас өөр газарт хөрс хуулалт хийх, шинээр карьер нээх буюу уурхайн нээлт хийх үед уурхайн дарга, ашиглалтын инженерийн зааврын дагуу уурхайн зураг төслийн ажилд тулгуурлан ажлыг гүйцэтгэх хэрэгтэй. Талбай дахь бэлчээр тэжээлийн үнэт ургамлуудыг хамгаалах мөн биологийн нөхөн сэргээлтэд нутгийн унаган ургамлыг тарих, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.

3.7 Амьтны аймаг

Бүс нутгийн экосистемийг шүтэн амьдардаг зэрлэг ан амьтан, хөхтөн, шувуудын биологийн олон янз байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Амьтдын амьдрах орчин доройтох, идэш тэжээлийн хомсдол бий болох, бэлчээр нутаг хумигдах, ундны усандаа хүрч чадахгүй байх зэргээс амьтдын тоо толгой буурч, нүүдэл шилжилт хөдөлгөөн бий болох зэрэг нөлөөллүүд гарах нь тодорхой боловч тус бүс нутагт дээрх үүсэх нөхцөл байдал амьтдын талаар хийсэн судалгаа шинжилгээний ажил байхгүй байна.

Уурхайн олборлолт явуулах бүсийн ойролцоо амьтдын орогнох нүх үүр эвдэгдэж сүйтгэгдэхээс сэргийлэх, олборлолтын талбай дахь байгууламжийн ашиглалтын хугацаанд машин техникийн дуу чимээ, агаарын бохирдол, технологийн болон ахуйн хог хаягдлыг багасгахад анхаарч, байгаль орчинд халгүй технологи хэрэглэхэд анхаарах, хайгуул, олборлолтын үед үүссэн илүүдэл нүх, цооног, овоолсон шороо зэргийг тухай бүрт нь нөхөн дүүргэх ажлыг хийн хуучин байдалд нь оруулан, техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг цаг хугацаанд нь чанартай хийж зохих шатны хяналтын байгууллагад хүлээлгэн өгөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

3.8 Нийгэм эдийн засаг

Төсөл хэрэгжсэнээр 22 хүний ажлын байр бий болж, нутгийн хүн ам ажлын байртай болсноор орон нутгаас бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэх, үйлчилгээний

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-62000084 ТООТ
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ” ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН
ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

салбарт өсөлт гарах замаар эерэг нөлөө үзүүлэх бөгөөд бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг тодорхой хэмжээгээр дэмжих боломжтойг илтгэж байна.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгүүд болон Байгаль орчин, Аялал жуулчлалын яамны уг төсөлд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагууд дээр үндэслэн тодорхойлсон. Мөн 2012 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан байгаль орчны багц хуулиуд Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Хөрс хамгаалах, Цөлжилтөөс сэргийлэх тухай, Ургамал хамгааллын тухай, Амьтны тухай, Агаарын тухай, Хог хаягдлын тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай зэрэг хуулиуд түүнтэй холбогдох бусад хуулиудад орсон өөрчлөлтүүд ялангуяа аж ахуйн нэгжийн байгаль хамгаалах талаар хүлээх үүргүүдийг тусгасан болно.

Тоосгоны шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны менежементийн төлөвлөгөөнд 2025 онд урьдчилсан байдлаар **6,013 мян төгрөг /Зургаан сая арван гурван мянган төгрөг /зарцуулахаар тусгасан.**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар уурхайн олборлолтын үед гарч болзошгүй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, нэгэнт бий болсон сөрөг үр дагаврыг бага гэлтгүй тухай бүр нь нөхөн сэргээх замаар төслийг байгаль орчинд ээлтэйгээр хэрэгжүүлэх бололцоотой юм.

БОМТ-г хэрэгжүүлснээр дараах зорилтууд хангагдана. Үүнд:

- Монгол улсын БОАЖЯ- наас тавьж буй байгаль орчныг нөхөн сэргээх болон сөрөг нөлөөллийг бууруулах талаар тавьж буй шаардлагыг аль болохоор хангасан байх;
- Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны шат дамжлага бүрт технологийн журам зааврыг байгаль хамгаалах хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, стандарт шаардлагад нийцүүлэх;
- Байгаль орчны менежментийн талаар БОНБНҮ-ээр дэвшүүлсэн зорилго зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг биелүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар төслийн холбогдох ажилтнуудад зориулан товч, тодорхой зааварчилгаа өгөх;
- Байгаль орчны менежментийн арга хэмжээ, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажиллагсдын үүрэг хариуцлагыг тогтоосон, удирдлагын шатлалын дараалал бий болгох;
- Төсөл хэрэгжүүлэгч буюу гэрээт гүйцэтгэгч бүр байгаль орчныг хамгаалахтай холбоотой үүрэг хариуцлагаа мэдсэн байх ба үүргээ биелүүлэхэд шаардлагатай ур чадвар, бэлтгэл сургалт, мэргэжилтэй байх;
- Байгаль орчинд гарч болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдлийг аль болохоор бууруулж, байгаль орчныг хамгаалж байгаль орчны тухайн төлөв байдлыг хэвийн хадгалах зорилтыг хангах үүднээс үүнд хамаарах тодорхой тогтолцоо, дэг журам, ажлын зааварчилгааг тодорхойлох;
- Тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг төлөвлөж явуулахад лавлах баримт бичиг болох

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-62000084 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ “АРВАЙНДЭВШИЛ”
ХХК-ИЙН 2025 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/				Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал		
1. Агаарын чанар									
1	Тээвэрлэлт, хүнд даацын машин механизмын нөлөөгөөр тоосжилт үүсэх	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгааг тогтсон хуваарийн дагуу хийх		Засвар үйлчилгээ	-	Хуваарийн дагуу	-	2025	Замын тэмдэг, техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2003 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ, техникийн ерөнхий шаардлага MNS 5885:2008
2		Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хурдны хязгаарлалтыг 40-50 км/цаг, уурхайн дотоод зам талбайд 20 км/цаг-аар мөрдүүлэн ажиллах, хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулах	Уурхайн дотоод болон гадаад тээврийн зам	-	100.0	5ш	500.0	2025	
3		Ашиглагдаж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийг стандартын түвшинд байлгах, агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслийн төлбөрийг төлөх	Уурхайд ашиглах тээврийн хэрэгслүүд		--	--	--	2025	
